



МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААН
ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ

ОЛОН УЛСЫН ДЭЭД БОЛОВСРОЛ СУДЛАЛЫН ТӨВ

МЭРГЭШЛИЙН ҮНДЭСНИЙ БҮДҮҮВЧИЛСЭН БҮТЭЦ

ДЭЭД БОЛОВСРОЛЫН
БОДЛОГЫН ӨӨРЧЛӨЛТ

ЦУВРАЛ
№9

2018 ОНЫ 5 САР



"Том зорилт өндөр амжилтанд хүргэнэ."



ОРШИЛ

Мэргэшлийн бүтцийг бүр эртний Грек, Ром, Хятадад хэрэглэж байсныг түүхэн баримтууд гэрчилж байна. Нийгмийн хөгжлийн явцад ялангуяа Хятадад боловсролын түвшинг илэрхийлсэн шалгалтын систем бий болж, шалгалтын үр дүнгээр төрийн байгууллагад ажиллах эрх олгох болсон байна. XI зуунд Болони их сургуулийг байгуулснаар европын их сургуулийн уламжлал эх сууриа тавьж, тэр үеэс мэргэшлийн тухай ойлголт илүү тодорхой утга агуулгатай болсон байна. Бүх мэргэшлийг сургалтын хөтөлбөр болон боловсролын түвшингээр бус сурах үйл ажиллагааны үр дүнгээр илэрхийлэх санаа өнгөрсөн зууны эцсээр гарч ирсэн бөгөөд улс төрийн “буцалсан тогоо” дотор хүчтэй дэмжлэг авснаар анхны мэргэшлийн үндэсний бүдүүвчилсэн бүтцийг Австрали, Англи, Шотланд, Шинэ Зеланд, Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улс зэрэг улс орнууд бий болгосон байна. Ийнхүү өнгөрсөн зууны ерээд оноос дэлхий дахинаа боловсролын системд хийж байгаа өөрчлөлт шинэчлэлийн нэг чухал чиглэл нь мэргэшлийн үндэсний бүдүүвчилсэн бүтэц (МУББ) зохиох асуудал болж ирлээ. Мэргэшлийн үндэсний бүдүүвчилсэн бүтэц зохиох ажлыг барууны

улс орнууд санаачилж хэрэгжүүлж эхэлсэн бол сүүлийн жилүүдэд бусад бүх улс орнууд ийм бүтэцтэй болохыг зорьж ажиллаж байна.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын тодорхойлсноор мэргэшлийн бүдүүвчилсэн бүтэц нь сурах үйл ажиллагааны үр дүнд хүрсэн түвшинг тодорхойлох шалгууруудын дагуу мэргэшлүүдийг ангилж үзэх хэрэгсэл юм. Эдгээр шалгуур үзүүлэлтүүд нь тухайн мэргэшлийн тодорхойлолтод онцгойлон заагдсан байхаас гадна мэргэшлийн түвшингийн тодорхойлолтод багтаж бас болно. Мэргэшлийн бүдүүвчилсэн бүтцийг анхан шатны боловсрол, насанд хүрэгчдийн боловсрол, ур чадварын боловсрол зэрэг боловсролын системийн янз бүрийн түвшинд тус тусад нь боловсруулахын зэрэгцээ боловсролын системийн бүхий л шатыг хамруулан боловсруулах тал дээр улс орнууд онцгой анхаарал тавих болжээ. Мэргэшлийн бүдүүвчилсэн бүтэц нь боловсролын чанарыг дээшлүүлэх, хүртээмжийг өргөтгөх, боловсролын янз бүрийн түвшингийн хоорондын болон боловсрол ба зах зээлийн уялдаа холбоог сайжруулах, мэргэшлийг эх орондоо төдийгүй олон улсад хүлээн зөвшөөрүүлэх зорилготой юм.

МЭРГЭШЛИЙН ҮНДЭСНИЙ БҮДҮҮВЧИЛСЭН БҮТЭЦ БОЛОВСРУУЛАХ АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ҮЕ ШАТ

Төрийн бодлого боловсруулагчдын зүгээс Мэргэшлийн үндэсний бүдүүвчилсэн бүтцийг

боловсруулж батлах талаар баримтлах бодлогын гол асуудлуудыг дэс дараатай тодорхой авч үзье.

1 Мэргэшлийн үндэсний бүдүүвчилсэн бүтцийг боловсруулах ажлыг юуны өмнө түүний зорилго, түүнийг бий болгосноор хүрэх үр дүнг сайтар бодож төлөвлөхөөс эхлэх хэрэгтэй. Дэлхийн улс орнууд МУББ-ийг янз бүрийн зорилготой боловсруулж хэрэгжүүлж байна. МУББ-ийг боловсруулж хэрэгжүүлэх хамгийн түгээмэл зорилго бол насан туршийн боловсролыг дэмжих, боловсролын чанарын баталгаажуулалт болон мэргэшлийг улс орныхоо хэмжээнд төдийгүй олон улсын

хэмжээнд хүлээн зөвшөөрүүлэх асуудлыг бүрэн шийдвэрлэх явдал юм. Өнөөдөр сургууль, коллеж, их дээд сургуульд залуучуудыг сургаж албан боловсрол олгох явдал урдын адил чухал хэвээр байна. Гэхдээ дэлхийн бараг бүх улс орон насан туршийн боловсролын ач холбогдлыг хүлээн зөвшөөрч, түүнийг хөгжүүлэх, дэмжих бодлого хэрэгжүүлж эхэлж байна. Эдийн засгийн хөгжил, технологийн дэвшлийн үр дүнд сургууль төгссөн залуучууд, насанд хүрэгчдийн өмнө насан туршийн

тасралтгүй боловсролоор шинэ мэдлэг, ур чадвар эзэмших шаардлага тавигдах боллоо. Тасралтгүй сургалт нь ажил олгогчдын хувьд шаардлагатай ур чадвар бүхий мэргэшилтэй ажилчдын хэрэгцээг хангах, хувь хүний хувьд эдийн засгийн баталгаатай орлоготой болоход тустай юм. Түүнээс гадна сургуулиа орхисон, завсардсан залуучуудад эргэж үргэлжлүүлэн сурах боломж олгохоос гадна МҮББ- нь шинэ мэргэшлийг бий болгох, түүнийг эзэмших

боломжийг өргөтгөх гол хэрэгсэл болж байдаг. Өнөөдөр нэг сургуульд суралцаж эзэмшсэн хичээл, мэргэшлийг нөгөө нэг сургууль нь хүлээн зөвшөөрөхгүй байх явдал олонтаа тохиолддог. Тэгвэл, МҮББ нь тодорхой түвшингээр ахин дэвшин боловсрол мэргэшил эзэмших зам мөрийг тодорхой болгож өгдөг учраас суралцагчдын сурч эзэмшсэн мэдлэг, ур чадварыг хүлээн зөвшөөрөх хэрэгцээ шаардлагыг бүрэн хангаж байдаг.

2 МҮББ-д боловсролын ямар түвшинг хамруулах тухай асуудал нь бодлого боловсруулагчдын хувьд шийдэх ёстой дараагийн асуудал юм. Дунд боловсрол, техник мэргэжлийн болон ур чадварын боловсрол, дээд боловсрол гэсэн 3 түвшинг хамруулсан МҮББ боловсруулах хандлага давамгайлах болж байна. Гэхдээ боловсролын аль нэг түвшинг хамарсан МҮББ байгуулж, дараа нь бусад түвшинг хамруулах хандлагыг баримтлах тохиолдол бас бий. Боловсролын бүх түвшинг хамарсан МҮББ байгуулах нь боловсролын янз бүрийн түвшингийн хоорондын уялдаа холбоог сайжруулж, нэгдсэн бодлого хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлдэг. Харин боловсролын түвшин бүр өөр өөрийн уламжлал, сонирхол, шаардлагатай байдаг учраас тэднийг нэгдсэн бүтцэд оруулах ажил удаашралтай бас бэрхшээлтэй тулгарах явдал гардаг. Шинэ Зеланд улс аль 1990 оноос МҮББ-г боловсролын бүх түвшинг хамруулан боловсруулж эхэлсэн боловч их дээд сургуулиуд тэрхүү санаачлагад ихээхэн эсэргүүцэлтэй хандаж байснаас харилцан

зөвшилцөлд хүрэхийн тулд арав гаруй жил зарцуулсан байна. МҮББ-г дэлхийн олон улс оронд эхлээд техник мэргэжлийн болон ур чадварын боловсролын түвшинд боловсруулж хэрэглэх хандлага түгээмэл байна. Нөгөө талаас, Дэлхийн Хөдөлмөрийн байгууллагаас энэхүү ажлыг дэмжиж, сургалт зөвлөмж олноор зохион явуулж байна. Энэ хандлагын давуу тал нь тухайн шийдвэрлэвэл зохих асуудлыг, тухайлбал, тодорхой мэргэшлийн ажилчдын хэрэгцээг хангах асуудлыг шийдэхэд хүчээ төвлөрүүлэх боломж олгодогт оршино. Харин боловсролын нэг түвшинг хамарсан МҮББ боловсруулаад түүндээ бусад түвшинг хамруулах ажил ихээхэн хугацаа шаарддаг байна. Тухайлбал, Шотланд улс 20 гаруй жил зарцуулж байж, боловсролын бүх түвшинг хамарсан МҮББ-г боловсруулсан байна. Сүүлийн жилүүдэд ЮНЕСКО-оос ялангуяа дээд боловсролын түвшинд МҮББ боловсруулах тал дээр гишүүн орнуудынхаа чадавхийг дээшлүүлэх сургалт семинар зохиож эхэлсэн байна. Манай улсад ч энэ онд энэ сэдвээр семинар явагдсан байна.

3 Ихэнх улс орнуудад сургуулийн боловсрол, ур чадварын боловсрол, дээд боловсролын хооронд уялдаа холбоо сул тус тусдаа хөгжиж ирсэн уламжлал бий. Тийм учраас мэргэшлийн цол зэрэг олгох систем ч тус тусдаа явж ирсэн байна. Харин зарим нэг оронд тэдгээрийн хооронд уялдаа холбоо тогтоох талаар тухайлбал, кредит тооцох зэрэг арга хэмжээ авч байна. Өөр нэг хэлбэр нь

бүх шатны боловсролоор мэргэшлийн зэрэг, цол олгох нэгдсэн системтэй болох чиглэлийг баримталж байна. Өмнөд Африкийн Бүгд Найрамдах улс ийм нэгдсэн систем хэрэгжүүлж байгаа жишээ болно. Аль хэлбэрийг сонгох нь МҮББ боловсруулж хэрэгжүүлэх зорилготой шууд холбоотой юм. Түүнээс гадна мэргэшлийн зэрэг, цол олгоход төрийн зүгээс тавих хяналтын цар хүрээтэй ч холбоотой.



- 4** МҮББ боловсруулах ажлыг боловсролын системийн өөрчлөлт шинэчлэл, эрх зүйн шинэчлэлтэй нарийн уялдаатай явуулахгүй бол ийм систем зохиосны үр өгөөж маш бага юм. Тиймээс МҮББ зохиох ажлыг боловсролын системийн урт хугацааны үзэл баримтлалтай нягт уялдаатайгаар явуулбал зохино.
- 5** МҮББ боловсруулах талаар өнөөдөр олон улс орны туршлага бий учраас түүнийг боловсруулахад хөрөнгө их шаардагдахгүй. Харин түүнийг хэрэгжүүлэхэд ихээхэн хөрөнгө мөнгө шаардагдана.
- 6** МҮББ зохиохдоо түвшин бүрийн тодорхойлолтыг сайтар бодож гаргах учиртай. Мөн мэргэшлийг бүртгэх, магадлан итгэмжлэх журам, шалгуурыг нухацтай боловсруулах хэрэгтэй.
- 7** Дараагийн нэг чухал асуудал бол МҮББ-ийн удирдлагын асуудал юм. Гол төлөв МҮББ-ын удирдлагыг бие даасан, Засгийн газраас үл хамааралтай боловч Засгийн газарт ажлаа тайлагнадаг тусгай бүтэц гүйцэтгэдэг. Энэ нь нэгд, Засгийн газар МҮББ-г боловсрол, мэргэшлийн талаарх төрийн бодлогыг хэрэгжүүлэх хэрэгсэл болгож ашигладаг боловч түүнийг боловсруулах шатанд гарах санал зөрчлүүдийг шийдвэрлэхэд шууд оролцохоос зайлсхийдэг учраас бие даасан бүтэц байхыг дэмждэг. Хоёрт, боловсролын байгууллагууд болон нийгмийн зүгээс МҮББ-ийг боловсруулж, хэрэгжүүлэхэд гардан оролцсноор энэ ажил үр дүнтэй, өгөөжтэй болдог. Харин Засгийн газрын удирдлага дор ийм бүтэц байвал оролцогчдын идэвх буурах, түүний хэрэгжилт саад бэрхшээлтэй тулгарах тохиолдол бий. Энэ бүхнээс үндэслээд Засгийн газар МҮББ-ийг байнгын ажиллагаатай байлгахын тулд тусад нь бие даалгах сонирхолтой байдаг.
- 8** МҮББ-ийн удирдлагын байгууллагын үндсэн үүрэг, үйл ажиллагаа нь МҮББ-ийг хэрэгжүүлэх, стандарт болон мэргэшлийн тодорхойлолт, шалгуурыг шинэчлэх, шинээр бий болгох, боловсролын чанарын баталгаажуулалт, үнэлгээ хийх зэрэг 4 гол зүйл дээр төвлөрдөг.
- 9** Мэргэшлийн үндэсний бүдүүвчилсэн бүтцийн түвшинг тодорхойлох нь төрийн бодлогын түвшинд авч үзвэл зохих асуудал юм. МҮББ-ийн нэг түвшинд хамаарагдаж байгаа мэргэшлүүдийг яг ижил гэж ойлгож болохгүй. Нэг түвшингийн мэргэшлүүдийг дүйцүүлж болох боловч зорилго, цар хүрээгээрээ ялгаатай байж болно. Тухайлбал, аль нэг мэргэшил эзэмшиж авснаар цаашид дэвшин сурах бэлтгэл хангах зорилготой байхад, өөр нэг мэргэшлээр сурч олж авсан цогц чадамжаа ашиглан хөдөлмөрийн зах зээлд ажиллах зорилготой байж бас болно. Тухайн түвшинд хамрагдах мэргэшлүүдийг дүйцүүлэх боломжтой гэдэг нь тэд тухайн түвшний тодорхойлолтод орсон шалгууруудыг хангаж байна гэсэн үг юм. Тухайн түвшний тодорхойлолтыг сурах үйл ажиллагааны үр дүнгээр тодорхойлдог. МҮББ-ийн түвшингийн тоог улс орнууд өөрсдийн нөхцөлд тохируулан тодорхойлдог. Зарим улс оронд 12 түвшин тодорхойлсон тохиолдол байхад заримд нь түүнээс цөөн тэр ч байтугай тавхан түвшинтэй байхаар тодорхойлсон байна. Европын Холбооноос 8 түвшинг санал болгосныг нилээд олон улс орон баримжаа болгон авч байна.


Түвшин	Зэрэг цол	Цогц чадамжийн жишээ
8	Докторын зэрэг	Тодорхой бус нөхцөлд ажиллах мэдлэг, бүтээлч чадвар, манлайлах чадвар шаардах ажил. Дээд зэрэглэлийн менежер
7	Магистрын зэрэг	Мэдлэгт суурилсан нарийн мэргэшлийн ажил хийх мэргэжилтэн. Удирдах ажлын ур чадвартай байх.
6	Бакалаврын зэрэг	Мэргэшлийн ур чадвартай, дунд шатны удирдах ажил хийх боломжтой
5	Дээд боловсролын диплом	Нарийн мэргэшлийн ажилчин, техникчийн ажил хийх чадвар эзэмшсэн
4	Ахлах сургууль төгссөн гэрчилгээ	Мэргэшлийн ур чадвартай ажилчин
3	Дунд сургуулийн гэрчилгээ Тодорхой чиглэлийн чадвар эзэмшсэн	Ур чадвар эзэмшсэн ажилчин
2	Мэргэшлийн анхан шатны чадвар	Ажлын байранд шаардагдах анхан шатны ур чадвар эзэмшсэн
1	Бичиг үзэгт тайлагдсан, тоо бодох чадвар Ажилд орох ба цаашид мэргэшил эзэмших анхан шатны чадвартай	Ажил хийж эхлэх, ур чадварын сургалтанд орох бэлтгэл хангасан



БАРИМТ 1 - ИРЛАНДЫН МҮББ

Ирланд бол харьцангуй цөөн хүн амтай улс төрийн хувьд тогтвортой, боловсролын үйлчилгээ үзүүлэгчид нь зохион байгуулалт сайтай өөр хоорондоо хамтран ажилладаг, английн боловсролын системийн уламжлалтай нээлттэй эдийн засагтай орон юм. 2003 оноос МҮББ байгуулах ажлыг эхлүүлж, насан туршийн

боловсролыг дэмжих, сургалтын чанар, стандартыг сайжруулах, боловсрол эзэмших хүртээмжийг нэмэгдүүлэх, боловсролын үе шат дэвшин суралцах боломжийг дээшлүүлэх зорилго тавьжээ. Ирландын МҮББ бол өргөн хүрээг хамарсан, үр дүнд суурилсан, 10 түвшинтэй, хэд хэдэн онцлох дэд түвшинтэй.



МҮББ-ИЙН ТҮВШИНГИЙН ТОДОРХОЙЛОЛТЫГ БОЛОВСРУУЛАХ АРГА

МҮББ-ийн түвшинг тодорхойлохдоо юуны өмнө сурах үйл ажиллагааны үр дүнд тулгуурлах нь өнөөгийн онцлог болж байна. Сурах үйл ажиллагааны үр дүнд бол боловсролын системийн өнөөгийн өөрчлөлт шинэчлэлийн чухал хэрэгсэл болж байна. Сурах үйл ажиллагааны үр дүнгийн олон янзын тодорхойлолт байдаг. Сурах үйл ажиллагааны эцэст суралцагч юу мэддэг, ойлгодог, юу хийж чаддаг болсныг харуулах эцсийн бүтээгдэхүүн, түүний тодорхойлолтыг

сурах үйл ажиллагааны үр дүнд гэнэ. Сурах үйл ажиллагааны үр дүнд мэдлэг, чадвар, чадамж гэсэн өөр хоорондоо уялдаа холбоо бүхий 3 хэмжээсээр тодорхойлдог бөгөөд энэ нь мэргэшлийн түвшин тогтооход чухал ач холбогдолтой юм. Тийм учраас энэ 3 хэмжээсийг цаашид нарийвчлан авч үзэх шаардлага зайлшгүй гарч ирнэ. Нэгд, мэдлэгийн тухай ойлголтыг нарийвчлан авч үзвэл дараах ангиллыг олж болно.

Эмпирик мэдлэг. Эмпирик мэдлэг бол хүний мэдрэхүйн эрхтний тусламжтайгаар туршилт хийх замаар олж авсан мэдлэг байна. Мэдлэгийн эх сурвалж нь мэдрэмж гэж эртний Грекийн эмпирик философчид үздэг байжээ.

Рационал мэдлэг. Учир шалтгааныг эргэцүүлэн бодох замаар бий болсон мэдлэгийг рационал мэдлэг гэнэ. Мэдлэгийн эх сурвалж нь учир шалтгаан, оюун ухаан гэж үздэг философичдыг Платон төлөөлж байдаг.

Идеалист мэдлэг. Туршилтаар олж авах бус зөн билигээр олж авсан мэдлэгийг идеалист мэдлэг гэнэ. Кантын гаргаж ирсэн томъёоллоор “мэдлэг бол оюун бодол, мэдрэх чадвар хоёрын синтез мөн”.

Конструктивист мэдлэг. Сурахуй, хүртэхүй, ойлголт, сэтгэхүй зэрэг танин мэдэхүйн ачаар олж авсан мэдлэг юм. Пиажийн сэтгэл зүйн судлал энд чухал үүрэг гүйцэтгэсэн байна.

Социо-конструктивист мэдлэг. Суралцагчдыг сурах үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулах замаар олж авсан мэдлэгийг хэлнэ. Выгодский, Бруннер нарын дэвшүүлсэн онол юм.

Бихевиорист мэдлэг. Аливаа гадны нөлөөнд хувь хүний зүгээс үзүүлэх хариу үйлдэл, чадамжаа илэрхийлэх чадварт чиглэсэн мэдлэг. Скиннер энэхүү онолыг дэвшүүлсэн байна.

Түүнээс гадна сурах үйл ажиллагааны үр дүн нь ил, далд, шигтгэн суулгасан зэрэг мэдлэгийн

хэлбэрүүдийг илэрхийлэхэд хэрэглэдэнэ.

Хоёрт, ур чадварын тухай ойлголтыг гол төлөв хөдөлмөрийн зах зээлтэй уялдуулан авч үздэг бөгөөд Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас чадвар бол “дэлхий нийтийн шинэ үнэт цаас”

гэж тодорхойлжээ. ЮНЕСКО-оос 2012 онд гаргасан “Бүх нийтийн боловсролын хяналт, үнэлгээний дэлхийн тайлан”-д суурь, хөрвөх, техникийн болон мэргэжлийн гэсэн үндсэн гурван төрлийн чадварыг тодорхойлсон байна.



Суурь ур чадвар: Хамгийн энгийн нь гэж болох суурь ур чадвар нь хүний өдөр тутмын хэрэгцээг хангахуйц хөлсний ажил олоход зайлшгүй шаардлагатай бичиг үсгийн ба тоо бодох чадвар юм.

Техникийн болон мэргэжлийн чадвар: Олон төрлийн ажлын байр нь тусгай техник, мэргэжлийн мэдлэг чадвар шаардана. Тухайлбал, үр суулгах машин ашиглан ногоо тарих, тоосго өрөх, мужааны ажил хийх, компьютер дээр ажиллах зэргийг дурдаж болно.

Хөрвөх чадвар: Янз бүрийн ажлын байрны хэрэгцээ шаардлага, нөхцөл байдалд хэрэглэж болох, ажил хайж олох, түүн дээрээ тогтож ажиллахад шаардлагатай өргөн хүрээтэй чадваруудыг хөрвөх чадвар гэнэ. Асуудлыг задлан шинжлэх, зохих шийдлийг олох, өөрийн санаа болон мэдээллийг оновчтой хүргэх, ажилдаа бүтээлч хандах, манлайлал ба ухамсартай байдлаа харуулах, энтерпренер авьяас чадвараа үзүүлэх зэргийг хөрвөх чадварт багтаана.

Гуравт, мэдлэг, чадварыг тодорхой нөхцөл байдалд хэрэглэхийг цогц чадамж гэнэ. Чадамжийг олон янзаар ангилж авч үздэг. Сэтгэл

зүйчдийн гаргасан ангиллаар цогц чадамжийг дараах 3 төрөлд хуваана.

Төсөөлөх чадамж.

Тухайн сэдвийн тухай хийсвэр мэдлэг, дүрэм журамд тулгуурласан чадамж юм.

Горимын чадамж.

Төсөөлөх чадамжийг тодорхой нөхцөлд хэрэглэхэд шаардлагатай ур чадвар, дэс дараалал тогтоох чадамж юм.

Үйлдлийн чадамж.

Аливаа асуудлыг ойлгож, түүнийг шийдэхэд тохирох стратегийг олох чадамж юм.

Түүнээс гадна хэрэглээний цогц чадамж гэсэн ойлголт нь мэдлэг чадварыг хэрэглэхтэй уялдаж

гарч ирсэн байна. Хэрэглээний цогц чадамжийг дараах байдлаар 3 ангилдаг.

Суурь чадамж. Мэдээлэл боловсруулах, асуудал шийдэх, асуудлыг задлан шинжлэх, синтез, үнэлгээ хийх зэрэг оюуны чадварыг хэлнэ.

Практик чадамж.

Чадамжаа үйлдэл дээр харуулахыг хэлнэ.

Хариу үзүүлэх чадамж.

Хувь хүн аливаа нөхцөлд зөв хариу үйлдэл үзүүлэх чадвар юм.



Мэдлэг, чадвар, цогц чадамж гэсэн энэ 3 хэмжээс нь Делорын тайланд тодорхойлсон суралцахуйн 4 тулгуур зарчимтай шууд холбоотой байна. Үүнд: Мэдэхийн тулд суралцах зарчим нь мэдлэгтэй, хийж чадахын тулд суралцах зарчим нь ур чадвартай, хүн

болохын тулд суралцах зарчим нь чадамжтай шууд харгалзан зохицолдож байна. Харин хамт амьдрахад суралцах зарчим нь дээр дурдсан мэдлэг, чадвар, цогц чадамжид бүгдэд хамааралтай байна.

МЭРГЭШЛИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ТУХАЙ

Мэргэшлийн тухай олон янзын тодорхойлолт байдаг. ЮНЕСКО, ОУХБ, Европын Холбоо зэрэг байгууллагууд мэргэшлийн тухай тодорхойлолтыг гаргасан байдаг. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас мэргэшил гэдгийг “Тусгай стандартуудад

заасан мэдлэг, чадвар, цогц чадамжийг хувь хүн сурч эзэмшсэнийг албан ёсны эрх бүхий байгууллагаас тогтоож өгөхийг хэлнэ” гэжээ. Мэргэшил эзэмших үйл явц нь гол төлөв дараах 5 төрлийн элементээс бүрдэнэ.

Үүнд:

Сурах үйл ажиллагаа. Мэргэшил эзэмших үндэс нь хувь хүн албан ёсны сургалт болон ажлын байран дээр дагалдан сурч дадлага эзэмших, бие даан сурах, нийгэм хамт

олны үйл ажиллагаанд оролцох замаар мэдлэг, чадвар, цогц чадамж олж авах үйл ажиллагаа юм.

Үнэлгээ. Сурах үр дүнгийн стандарт, шалгуурын дагуу хувь хүний эзэмшсэн

мэдлэг чадвар, цогц чадамжийг үнэлж дүгнэхийг хэлнэ.

Баталгаажуулалт. Хувь хүний сурах үйл ажиллагааны үнэлгээ нь урдаас тодорхойлсон шалгуурт нийцэж байгаа болон үнэлгээ хийх

үйл явц нь дүрэм журмын дагуу явагдсныг баталгаажуулж, чанарын баталгаа гаргахыг хэлнэ.

Гэрчилгээ олгох. Хувь хүний сургалтын үр дүнг баталгаажуулсныг илэрхийлсэн баримт бичгийг хүлээн зөвшөөрөгдсөн тусгай нэр хүнд бүхий байгууллагаас олгохыг хэлнэ.

Энэхүү гэрчилгээ нь хувь хүний цаашид суралцах, хөдөлмөрийн зах зээлд тодорхой үүрэгтэй оролцох эрхийг олгож байдаг.

Хүлээн зөвшөөрөх. Өмнөх 4 үе шатны дараах үе шатанд хувь хүний эзэмсэн мэдлэг, чадвар, цогц чадамжийг гуравдагч этгээдээс үнэлж, шинэ ажил санал болгох,

цалин хөлс нэмэх, нийгмийн статусыг өргөх замаар хувь хүний өөртөө итгэх итгэл урам зоригийг нэмэгдүүлж байдаг.



ОЛОН УЛСЫН КОНВЕНЦИ

Дэлхийн II дайны дараагаас мэргэшлийг хүлээн зөвшөөрөх асуудлыг дэмжсэн санаачлагууд гарч ирж байсан бөгөөд ЮНЕСКО энэхүү санаачлагуудыг удирдан чиглүүлж ирсэн байна.

Үүнд:

- Латин Америк болон Карибийн тэнгисийн орнуудад дээд боловсролын сургалт, гэрчилгээ, диплом, зэргийг хүлээн зөвшөөрөх олон улсын конвенц (1974 он)
- Газрын Дундад тэнгисээр хил залгасан Араб болон Европын орнуудад Дээд боловсролын сургалт, гэрчилгээ, диплом, зэргийг хүлээн зөвшөөрөх олон улсын конвенц (1976)
- Арабын улс орнуудад Дээд боловсролын сургалт, диплом, эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх конвенц (1978)
- Африкийн улс орнуудад Дээд боловсролын сургалт, гэрчилгээ, диплом, эрдмийн зэрэг болон бусад мэргэшлийг хүлээн зөвшөөрөх бус нутгийн конвенц (1981, Арушагийн Конвенц гэж нэрлэдэг)
- Ази, Номхон далайн улс орнуудад Дээд боловсролын сургалт, гэрчилгээ, диплом, эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх бус нутгийн конвенц (1983)
- Европын бус нутагт Дээд боловсролын мэргэшлийг хүлээн зөвшөөрөх ЮНЕСКО, Европын зөвлөлийн хамтарсан конвенц (1997, Лисабоны конвенц гэдэг)
- Дээд боловсролын мэргэшлийг хүлээн зөвшөөрөх Ази, Номхон далайн бус нутгийн конвенц (2017)
- Дээд боловсролын сургалт, мэргэшлийг хүлээн зөвшөөрөх зөвлөмж (1993)

ЮНЕСКО-ийн 37-р Ерөнхий бага чуулганаас дээд боловсролын мэргэшлийг хүлээн зөвшөөрөх дэлхий нийтийн конвенц боловсруулах ажлыг эхлүүлэхийг санал болгосон бөгөөд ЮНЕСКО-оос тусгай экспертийн хэсэг ажиллууж, энэ

асуудлыг судалсан тайлангаа өнгөрсөн оны 11 сард болсон ЮНЕСКО-ийн 39-р ерөнхий бага чуулганд танилцуулж, дэмжлэг авч, уг конвенцийг дараагийн Ерөнхий бага чуулганаар хэлэлцүүлж батлуулахаар болжээ.

СУРАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭМЖҮҮРҮҮД

Сурах үйл ажиллагааны үр дүн, цогц чадамжийг хэмжих зорилгоор олон улсын хэмжээнд хэрэглэж буй судалгааны аргуудыг сурах үйл ажиллагааны хэмжүүр гэж нэрлэж байна. Түүний анхны жишээ бол ЮНЕСКО-ийн Статистикийн хүрээлэн, АНУ-ын Бруклины хүрээлэнтэй хамтран боловсролын орчин үеийн тулгамдсан асуудлыг тодорхойлох зорилгоор олон улсын 30 байгууллага, 118 орны 186

экспертүүд, 1700 зөвлөхүүдийг оролцуулан өргөн хүрээтэй судалгаа хийж, гол анхаарлаа боловсролын хүртээмжид төдийгүй, сурах үйл ажиллагаанд хандуулах цаг болсныг зөвлөж, улмаар сурах үйл ажиллагааны 7 чиглэлийг чухалчлан тодорхойлжээ. Үүнд, бүх нийтийн боловсрол, сурах үйл ажиллагаа ба насны онцлог, унших чадвар, тоо бодох чадвар, сурахад бэлтгэгдсэн байдал, дэлхийн иргэн

болох, сурах боломжийг өргөтгөн гүнзгийрүүлэх зэрэг 7 чиглэлийг сургуулийн өмнөх, бага, бага сургуулийн дараах түвшинд тодорхойлсон байна.

Өөр нэг жишээ бол Дэлхийн банкнаас бодлого боловсруулагчид, судлаачдад зориулсан STEP аргачлал юм. Энэ аргачлал нь эдийн засгийн өсөлт, бүтээмжийг нэмэгдүүлэхийн тулд ур чадварыг шингээх механизмыг боловсруулахад чиглэж байдаг бөгөөд хүүхэд ажлын гараагаа зөв эхлэх, бүх хүүхэд сурах чадвартай байх, ажил эрхлэгчдийн хэрэгцээнд тохирсон ажлын ур чадварыг бий болгох, инноваци, ажил хэрэгч байдлыг дэмжих, ур чадварын үйлдвэрлэлийг хэрэгцээнд тохируулах гэсэн өөр хоорондоо уялдаатай 5 үе шаттай байна. STEP аргачлал нь ур чадварыг хэмжихэд голлон анхаарч ур чадварыг хөгжүүлэх бодлого, стратегийг боловсруулахад тустай.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн

ЮНЕСКО-ийн Статистикийн хүрээлэнгээс бичиг үсгийн боловсролыг дээшлүүлэх, хяналт тавих зорилгоор LAMP олон улсын судалгааг явуулж

Түвшин 1. Бичиг үсгийн ур чадвар дорой. Тухайлбал, эмний тайлбарыг уншиж харгалзах

Түвшин 2. Хамгийн энгийн бичлэгийг унших чадвартай боловч бичиг үсгийн алдааг засахад

Түвшин 3. Өдөр тутмын ажил амьдралын хэрэгцээ шаардлагыг хангах энгийн суурь мэдлэг ур чадвартай байна. Ийм чадвартай

Түвшин 4 ба 5. Мэдээлэлтэй ажиллах дээд

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас эрхлэн явуулдаг PISA сонжоо бол 15 насны суралцагчдын мэдлэг, ур чадварыг үнэлдэг. 3 жилд нэг удаа явагддаг энэхүү үнэлгээ нь 72 орны 28 сая орчим 15 насны охид хөвгүүдийг хамардаг байна. PISA сургуулийн сургалтын хөтөлбөртэй огт холбоогүй бөгөөд оюутны сурах үйл ажиллагааны үр дүнг тэдний

байгууллагаас ур чадварын түвшинг үнэлэх, хянах, шинжлэн судлах талаар улс орнуудад туслах зорилгоор олон улсын PIAAC судалгааг санал болгож байна. Бичиг үсгийн болон тоо бодох чадвар, асуудал шийдэх ур чадварын түвшинд энэ судалгааны анхаарал төвлөрч байдаг. Энэ судалгаа нь нэг хэвийн давтагдсан ажил хийх хоцрогдсон шаардлагын оронд оюуны өндөр түвшин, харилцааны өндөр соёл шаардсан ажлын эрэлт хэрэгцээ эрс нэмэгдсэнийг хүлээн зөвшөөрч байна. Орчин үеийн нийгэмд шаардагдаж байгаа харилцааны ур чадвар, өөрийгөө удирдах, бие даан сурах чадвар зэрэг суурь ур чадвар болон гадаад хэлний мэдлэгийн хэрэгцээ шаардлага, технологийн мэдлэг чадвар зэрэг нийгэм, эдийн засгийн захиалгыг хүлээн зөвшөөрч байдаг. PIAAC судалгааг бенчмаркинг хийх зорилгоор ашиглах нь олонтаа тохиолддог.

байна. Бичиг үсгийн соёлыг 5 түвшингээр тодорхойлж байна.

тунгаар хүүхэддээ эм өгч чадахгүй хувь хүн.

бэрхшээлтэй тулгардаг.

хувь хүн дунд сургууль амжилттай төгсөж коллежид элсэх боломжтой.

түвшний мэдлэг чадвартай хувь хүн

сурах хүсэл эрмэлзлэл, нийгмийн байдалтай холбож авч үздэг байна.

Дэлхийн ур чадварын байгууллагаас ур чадварын тэмцээний дүнгээр ур чадвар, чадамжийг үнэлж, ур чадварын стандартын тодорхойлолтыг боловсруулж тэмцээний үндсэн баримт бичиг болгон ашиглаж байна.

АЖИЛ МЭРГЭШЛИЙН АНГИЛЛЫН СИСТЕМ

Олон улсын Хөдөлмөрийн байгууллагаас 1988 онд боловсруулж гаргаад, 2008 онд шинэчлэн засварласан ажил мэргэжлийн ангиллын систем ISCO-08 бол ажил мэргэшлийг үндсэн, туслах, дагавар гэж ангилахдаа ур чадварын түвшин, ур чадварын нарийн мэргэшил гэсэн 2 үндсэн

шалгуурыг ашигладаг. Ур чадварын түвшин гэдэг нь ажил үүргийн цар хэмжээ, нарийн түвэгтэй байдлыг тодорхойлж байдаг бол ур чадварын нарийн мэргэшил нь шаардагдах мэдлэг, ашиглах багаж төхөөрөмж, үйлдвэрлэх бүтээгдэхүүн үйлчилгээг тодорхойлно.



Энэхүү стандартын дагуу Монгол Улсын ажил, мэргэжлийн ангилал, тодорхойлолт (YAMAT-08) –ийг боловсруулж, түүндээ 3978 ажил мэргэжлийг оруулж, түүнээсээ 1254 ажил, мэргэжил буюу 31%-ийг “мэргэжилтэн” гэсэн ангилалд хамруулан тодорхойлсон байна. О*NET гэдэг нь ажил мэргэшлийн талаарх мэдээллийг нэгтгэн зохион байгуулсан мэдээллийн онлайн бааз юм. Энэхүү мэдээллийн баазад ажил болон ажилчдын тодорхойлолтыг 6 чиглэлээр тодорхойлсон байна. Үүнд, ажилчин хүний үндсэн шинж, түүнд тавих шаардлага, ажлын туршлагад тавих шаардлага, ажил мэргэшлийн шаардлага, ажиллах хүчний шинж тэмдэг, тусгай мэдээлэл гэсэн чиглэлийн мэдээллүүд багтдаг.

О*NET мэдээллийн бааз нь ажлын байрны

нэр, цаашлаад 1000 гаруй ажил мэргэшлийг хамарсан ангиллын системтэй байна. Энэ системийн нэгж нь ажлын байр, албан тушаалын нэр бус ажил мэргэшил байдаг учраас тодорхой байгууллагаас хамааралгүй болгож, нийтлэг шинж чанартай болгожээ. Сүүлийн үед О*NET системийг АНУ-аас гадна бусад орнууд хэрэглэх болж байна. Түүнээс гадна О*NET системтэй ижил төстэй ESCO системийг европын улс орнууд боловсруулж эхлээд байна. Энэ системийн онцлог нь хөдөлмөрийн зах зээл ба боловсролын секторын хоорондын уялдаа холбоог сайжруулах, ажил хайгчид ба ажлын байрыг онлайнаар холбож өгөх, сурах үйл ажиллагааны үр дүнг Мэргэшлийн европын бүдүүвчилсэн бүтцэд тусгах зэргээр илэрч байна.

БОЛОВСРОЛЫН АНГИЛЛЫН СИСТЕМ

Боловсролын ангиллын систем бол ажил мэргэшлийн ангиллын системтэй төстэй боловч албан боловсролд гол анхаарлаа төвлөрүүлж байдаг. Хамгийн өргөн хэрэглэгддэг боловсролын олон улсын ангиллын систем бол ISCED юм. 1997 онд ЮНЕСКО Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагатай хамтран ISCED –ийг боловсруулж, түүнээс хойш хэд хэдэн удаа нэмж засварласан байна. 2013 оны засварласан хувилбар нь мэргэшилд тулгуурлан боловсрол эзэмшсэн үе шатыг ангилснаар суралцах хугацаанд тулгуурласан уламжлалт аргаас цаашилж, үр дүнд тулгуурласан зарчмыг хэрэглэх боломжийг

нээж өгсөн байна. ISCED бол 4 оронтой кодчлолыг хэрэглэж, мэргэжлийн ерөнхий чиглэл, төрөлжсөн чиглэл, нарийвчилсан чиглэл гэсэн 3 түвшин бүхий статистикийн зориулалт бүхий боловсролын ангиллын систем юм. Энэхүү ангиллын системд боловсролын түвшинг хөтөлбөрүүдийг нэгтгэн бүлэглэж, дэс дараалал тогтоох замаар тодорхойлдог нь хөтөлбөрийн агуулгын гүнзгийрэлт, нарийвчиллыг илэрхийлж байдаг. Ийнхүү боловсролын хөтөлбөрийг түвшин ахих замаар ангилдаг нь боловсрол эзэмших янз бүрийн даялал, зураглалыг бүрэн бүтэн харуулах зорилготой юм.

ОЛОН УЛСАД КРЕДИТ ШИЛЖҮҮЛЭН ТООЦОХ НЬ

Сурах үйл ажиллагааны үр дүнг үнэлж, хүлээн зөвшөөрөх нэг чухал асуудал бол кредит шилжүүлэн тооцох явдал юм. Кредит шилжүүлэн тооцох асуудлыг зарим улс орнууд МҮББ-тэй уялдуулан шийдэх оролдлого хийж байхад зарим нь тусад нь шийдэж байна. Тухайлбал, Европын холбооноос Европын

МББ-ийн зэрэгцээ ECVET ба ECTS гэсэн хоёр механизмыг хэрэглэж байна. Ур чадварын боловсролын хүрээнд кредит шилжүүлэн тооцох ECVET системийг хэрэгжүүлэх ажил ихээхэн хүндрэлтэй тулгарч байхад дээд боловсролын хүрээнд ECTS системийг өргөн хэрэглэж байна.

Хүснэгт. Мэргэшил, ур чадварыг хүлээн зөвшөөрөх,

үнэлэх төрөл бүрийн системүүдийн нэгдсэн тайлбар

	МББ	Бүс нутгийн конвенц	Сурах үйл ажиллагааны хэмжүүрүүд	Ажил мэргэшлийн ангиллын систем	Боловсролын ангиллын систем
Жишээ	МҮББ, Бүс нутгийн МББ	Европ, Африк, Латин Америк ба Карибын тэнгис, Ази-Номхон далай, Арабын улс орнууд	LMTF, STEP, PIAAC, PISA, WSSS	ISCO, O*NET, ESCO	ISCED, SBS
Зорилго	Мэргэшлийг ангилж, зохицуулалт хийх	Мэргэшлийг хүлээн зөвшөөрөх үйл ажиллагааг дэмжих	Ур чадварын түвшний талаар эмперик нотолгоо өгөх	Статистикийн зорилгоор ажил, мэргэшлийг ангилж, бүлэглэх	Статистикийн зорилгоор боловсролын хөтөлбөрүүдийг ангилах
Хамрах хүрээ	Албан боловсролоор олгох мэргэшлүүд	Дээд боловсролын мэргэшлүүд	Залуучуудаас эхлээд насанд хүрэгчдийг хамрах	Ажил мэргэшлийг хамрах	Албан боловсролын хөтөлбөрүүдийг хамрах
Оролцогч байгууллага	Засгийн газар, бүс нутгийн агентлаг	ЮНЕСКО Олон улсын болон бүс нутгийн байгууллага	ЭЗХАХБ Дэлхийн Банк, ЮНЕСКО Олон улсын байгууллагууд	ОУХБ Яамд, статистикийн байгууллага	ЮНЕСКО, ЭЗХАХБ, бүс нутгийн агентлаг
Анхаарал төвлөрүүлэх чиглэл	Мэдлэг, ур чадвар, цогц чадамж		Бичиг үсэг, тоо бодох зэрэг тусгай чиглэлд анхаарах	Статистикийн зорилгоор кодчилох	Статистикийн зорилгоор кодчилох
Түвшин	Түвшингийн тодорхойлолтыг хэрэглэх	Ерөнхий боловсрол, ур чадварын боловсрол, дээд боловсрол	Тухайн чиглэлээр өсөж дэвших	Ур чадварын түвшин	Ерөнхий чиглэл, төрөлжсөн чиглэл, нарийвчилсан чиглэл
Тулгуур ойлголт	Сурах үйл ажиллагааны үр дүн	Улс төрийн зөвшилцөл	Ур чадвар, цогц чадамж	Ур чадвар	Цогц чадамж Сурах хугацаа
Сурах үйл ажиллагааны үр дүнд шилжсэн	Тийм	Аажмаар шилжиж эхэлсэн	Зарим тохиолдолд	Аажмаар шилжиж эхэлсэн	Аажмаар шилжиж эхэлсэн
Эхэлж хэрэглэх болсон он	1990	1970	1960	1980 оны сүүлээс	1990 оны сүүлээс

МАНАЙ БОЛОВСРОЛЫН СИСТЕМД МҮББ БОЛОВСРУУЛЖ БИЙ БОЛГОХ ТАЛААР ӨГӨХ БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖҮҮД

МҮББ нь боловсролын салбарт оршиж байгаа олон тооны асуудлыг шийдэх хэрэгсэл болж чадах юм. Юуны өмнө нийгмийн эрх тэгш байдлыг хангах, эдийн засгийн өсөлтөд түлхэц болох гэсэн улс орны хөгжлийн 2 чухал асуудлыг шийдэх ач холбогдолтой юм. Суралцагчдад сурч боловсрох, мэргэшил эзэмших зам харгуй, зураглалыг тодорхой болгож өгснөөр, сонирхсон мэргэшлээ албан

болон албан бус боловсролоор олж авах өргөн боломжийг нээж өгч улмаар нийгмийн тэгш эрхийг хангана. Нөгөө талаас, мэргэшлийг зах зээлтэй уялдуулан улмаар өрсөлдөх чадварыг дээшлүүлснээр эдийн засгийн өсөлтөд чухал нөлөө үзүүлнэ. Ийм учраас МҮББ бий болгох ажлыг эрчимжүүлж, ойрын 3-5 жилд улс орны онцлог нөхцөлд тохирсон олон улсын стандартад нийцсэн МҮББ-тэй болох зорилт тавих хэрэгтэй.

Үүнд:

1 Дээд боловсролын хүрээнд МҮББ-ыг боловсруулж бий болгох талаар олон улсын төслийн хүрээнд эхэлж байгаа ажлыг өргөн

хүрээнд хэлэлцүүлж, улмаар УИХ-аар батлуулах ажлыг ойрын жилд хэрэгжүүлэх нь чухал юм.

Үүний тулд:

a Хөдөлмөрийн яамнаас боловсруулсан техник мэргэжлийн боловсролын түвшинг хамруулсан МҮББ-ийг одоо боловсруулж

байгаа дээд боловсролын МҮББ-тай уялдуулж нэг бүхэл бүтэн баримт бичиг болгох арга замыг хайх хэрэгтэй.

b МҮББ боловсруулах зорилго, үе шатыг нарийвчлан тодорхойлж, бэлтгэл ажилд

их, дээд сургуулиудыг идэвхтэй оролцуулж, өргөн хэлэлцүүлэг явуулах хэрэгтэй.

c МҮББ-ийн түвшингийн тодорхойлолтыг мэдлэг, ур чадвар, цогц чадамж гэсэн 3 үндсэн хэмжээсээр нарийвчлан боловсруулж, сурах үйл ажиллагааны үр

дүнг нухацтай сайтар боловсруулж, нэгдсэн ойлголтод хүрэх, улмаар энэ ажилд ажил олгогчдыг оролцуулах нь чухал юм.

d Дотоодын их дээд сургуулиудын хөтөлбөрийн уялдаа холбоог сайжруулах талаар тодорхой арга хэмжээ авч

хэрэгжүүлэн улмаар их, дээд сургууль хооронд кредит шилжүүлэн тооцох нэгдсэн аргачлалыг мөрдөж эхэлбэл зохино.

e МҮББ-ийн түвшингийн тодорхойлолтыг мэдлэг, ур чадвар, цогц чадамж гэсэн 3 үндсэн хэмжээсээр нарийвчлан

боловсруулж гаргасны үндсэн дээр МҮББ-ийг баталгаажуулах ёстой.

f МҮББ-ийг бий болгох асуудлыг боловсролын чанарын түвшинг дэлхийн нийтлэг түвшинд хүргэх, эх орондоо

олж авсан мэдлэг мэргэшлийг олон улсад хүлээн зөвшөөрүүлэх зорилгоор боловсруулж, хэрэгжүүлбэл зохино.

- 9 МҮББ-ийг боловсруулахтай уялдуулан насан туршийн боловсролыг хөгжүүлэх, албан бус болон ажил амьдрал дээр олж авсан мэдлэг чадвар, цогц чадамжийг хүлээн зөвшөөрөх, үнэлэх, баталгаажуулах асуудлыг нэг мөр шийдвэл зохино.

ХОЛБОГДОХ ЭХ СУРВАЛЖУУД

Allais, S. National qualifications frameworks: what's the evidence of success? Edinburgh: Centre for Educational Sociology. CES briefing; No 55. <http://www.ces.ed.ac.uk/PDF%20Files/Brief055.pdf>, 2011

Austrian Federal Ministry of Education Arts and Culture (2011). Consultation questions on UNESCO guidelines for recognizing all forms of learning with a focus on non-formal and informal learning. Vienna: BMUKK, in cooperation with 3s Unternehmensberatung Ltd.

Cedefop. Analysis and overview of NQFs in European countries: annual report 2015-16. 2017

Global inventory of regional and national qualifications frameworks 2017. Volume I: Thematic chapters, Volume II: National and regional cases. The European Centre for Development of Vocational Training (Cedefop), the European Training Foundation (ETF), the United Nations Educational, Scientific and Cultural Organisation (UNESCO), and the UNESCO Institute for Lifelong Learning (UIL), 2017

Credit and Qualifications Framework for Wales. Retrieved 29 May 2016.

Getting organised for better qualifications: a toolkit. Turin: ETF. http://www.etf.europa.eu/web.nsf/pages/Qualifications_toolkit 2016

SUMMARY

NQFs are seen as a solution to many of the problems within education and training systems. NQFs can contribute to achieving two significant development goals and rationales: social equity (by encouraging participation in raising educational achievement and developing more diverse learning pathways); and economic development (by linking qualifications more strongly to the labour market and competitiveness. This policy briefs provides a guidelines on the steps to be taken in order to develop NQF and focuses

on level descriptors, especially knowledge, skills and competencies dimension. Also it provides a holistic view of the different skill and occupational classification and education classification systems, learning metrics, as well as a regional conventions of recognition qualifications. This policy brief help you to understand a big picture of the different measures to improve the quality education and efficiency of the education system.

ШУТИС-ИЙН ОЛОН УЛСЫН ДЭЭД БОЛОВСРОЛ СУДЛАЛЫН ТӨВ

Тус төв энэ хичээлийн жилээс сар бүр дээд боловсролын тулгамдсан асуудлаар “Дээд боловсролын бодлогын өөрчлөлт” цувралыг хэвлэж гарган, мөн ШУТИС-ийн веб хуудсаар түгээх болно. Эдгээр цуврал нь дээд боловсролын бодлого боловсруулагчид, эрдэмтэн судлаачдад зориулагдсан бөгөөд энэ цувралын материалыг ашиглах, өөрсдийн судалгаанд ишлэл татан хэрэглэхийг бүрэн дэмжиж, Creative Commons нээлттэй лицензээр зохиогчийн эрхээ баталгаажуулсан.



Судалгааны баг

Доктор, профессор Д.Бадарч

Доктор, профессор Б.Очирбат

Доктор, дэд профессор Т.Намнан

Судлаач Б.Мөнххүж

Хянан тохиолдуулсан: Б.Очирбат

Хэвлэлд бэлтгэсэн: Ч.Болорчимэг

© ШУТИС Хэвлэлийн газар

